

ҮЗЗ-ийн уулзалтын тэмдэглэл

Уулзалтын талаар								
ГС-ийн ҮЗЗ		Монгол Улс			Хуралд санал өгөх эрхтэй гишүүдийн тоо			
Уулзалтын №		76						
Огноо		2018 оны 3 сарын 13			ҮЗЗ-ийн гишүүн бус оролцогчдын тоо, уригдаж ирсэн зочид			
ХУРЛЫН ДАРГА								
Нэр/ Байгууллага	Овог	Бямбасүрэн			Хурлын зорилгод хүрсэн эсэх (тийм, үгүй)			
	Нэр	Мягмар			Хурлын үргэлжилсэн хугацаа (цагаар)			
	Байгууллага	МҮЭ, Монголын Эрүүл Мэндийн ажилтны ҮЭ-ийн холбооны дарга			Хурал зохион байгуулагсан газар	Спрингс, хурлын танхим		
(Тохирох нүднийг бөглөнө үү)	ҮЗЗ-д гүйцэтгэх үүрэг	Дарга			x	Уулзалтын төрөл (Тохирох нүднийг бөглөнө үү)	Ээлжит	x
	Дэд дарга						Ээлжит бус	
	Гишүүн						Хорооны уулзалт	
	Гишүүнийг орлогч							
Салбар * (Тохирох нүднийг бөглөнө үү)								
ЗГ	ОУБ	ТББ	Боловсрол	Өвчлөлт бүлгийн хүн ам	Эредэлт бүлгийн хүн ам	Шашны Байгууллага	Хувийн Хэвшил	
						x		

ХӨТӨЛБӨР ТУС БҮРТ ХАМААРАХ СЭДВИЙГ СОНГОНО УУ (Тохирох нүднийг бөглөнө үү)								
ҮЗЗ-ИЙН ЗАСАГЛАЛ, ТОСОЛ ХӨТӨЛБӨРҮҮДТЭЙ ХОЛБООТОЙ СЭДВҮҮД								
Ажлын тэнц	ҮЗЗ-ийн жилийн ажлын төлөвлөгөө болон төслийн хянах	AC3	ҮЗЗ-ийн гишүүнчлэлийн асуудал	Тогтвортой байдал	ҮЗЗ болон хамтрагч байгууллагуудын уялдаа холбоо	Хүйсийн эрх тагш байдал	Төсөл боловсруулах	ҮХА, СХА
								Тэгзээр
								Хяналт (удирдлага, СОНА будаг)
								Санхүүжилтийг Үргэлжлүүлэн олгох талаар / төслийн II Үе, хамалт Техникийн шалгаруулалт авах
								Бусад

Хөтөлбөр								
№.	Хөтөлбөрийг дурдана уу							
Хөтөлбөр #1	Хурлын нээлт, хурлаар хэлэлцэх асуудлыг танилцуулах, өмнөх хурлын шийдвэрийн биелэлт							
Хөтөлбөр #2	ҮЗЗ-ийн дүрмийг хэлэлцэн, эцэслэн батлах							
Хөтөлбөр #3	Одоогийн хэрэгжүүлж буй төслүүдийн ололт амжилт, саад бэрхшээл							
Хөтөлбөр #4	ҮЗЗ-ийн 2017-2018 оны санхүүгийн тайлан, 2018-2019 ажлын төлөвлөгөө							
Хөтөлбөр #5	Бусад • ҮЗЗ-ийн Хяналтын Хорооны							

Хөтөлбөр тус бүрээр хийсэн тэмдэглэл		Хурлын иэлт, хурлаар хэлэлцэх асуудлыг танилцуулах, өмнөх хурлын шийдвэрийн биелэлт	
Хөтөлбөр #1		Ашиг сонирхолын зөрчилтэй оролцогчийн нэрийг дурдана уу.	
Ямар нэгэн маргаан гарсан эсэх(тийм эсвэл үгүй)>		ҮГҮЙ	
Тавьсан илтгэл, танилцууллын хураангуй			
Б.Мягмар: ҮЗЗ-ийн дарга Б.Мягмар хурлыг даргалан хурлын хөтөлбөрийг гишүүдэд танилцуулж, гишүүд саналгүй тул хөтөлбөрийг батлав. ҮЗЗ-ийн гишүүдийн бүрэлдэхүүн өөрчлөгдөн шинэ гишүүд олноор нэмэгдсэн тул хуралд оролцогчид өөрсдийгөө танилцууллаа.			
75 дах хурлын шийдвэрийн биелэлтийг ҮЗЗ-ийн зохицуулагч Б.Оюундарь танилцуулав.			
ХУРАЛ 2017 ОНЫ 10 САРЫН 13-НД БОЛСОН			
Хөтөлбөр		ХАРИУЦАЖ БУЙ ХҮН	Гүйцэтгэл
хөтөлбөр#2	<p>1. Цаашид хурлын хөтөлбөрийн хэлэлцэх асуудалд орсон аливаа асуудлын талаарх мэдээллийг заавал урьдчилан тараан өгч байх дүрмээр хүлээсэн үүргээ биелүүлэх хэрэгтэй гэдгийг ҮЗЗ-ийн Ажлын Алба, ХЗН-д үүрэг болгосныг гишүүд санал нэгтгэйгээр дэмжлээ. Ингэснээр ҮЗЗ яг юун дээр ХЗН-д хэрхэн дэмжлэг үзүүлэх тухайгаа мэдэх боломжтой болох ба ХЗН-ээс ямар асуудлыг хэрхэн тавих талаар бидэнд бичгээр ирүүлэх боломжтой.</p> <p>2. ҮЗЗ-ийн санхүүжилтын гүйцэтгэлийн тайланг дараагийн хурлаар танилцуулах үүргийг өглөө.</p>	АЖЛЫН АЛБА, ХЗН	100%
хөтөлбөр#3	ҮЗЗ-ийн гишүүд ЭМЯ-ны ТНБД болон Олон улсын төсөл хөтөлбөрүүд хариуцсан удирдагчтай байнга уулзан санал солилцож, төсөл хөтөлбөрийн үр дүнд гарах нөлөөллийг нэмэгдүүлэх, үйл ажиллагааны явцыг дэмжин ажиллахын тулд шаардлагатай боломж бололцоог бүрдүүлэн ажиллаж, зохих албан бичгийг ЭМЯ-нд өгөх болон Сүрьеэгийн эмийг ГС-ийн журмаар захиалан авах хүсэлтийг ЭМЯ-д уламжлах ажлыг ҮЗЗ-ийн Ажлын Албанад үүрэг болгон өгсөний дагуу ажиллаад явж байна. Оны өмнөхөн шинэ сайд томилогдсоной холбогдуулан ҮЗЗ-өөс үйл ажиллагаагаа танилцуулах тухай албан хүсэлт хүргүүлсэн боловч одоог хүртэл хариу нь ирээгүй байгаа.	АЖЛЫН АЛБА	80%
хөтөлбөр#5	<ul style="list-style-type: none"> • ҮЗЗ-ийн танилцах айлчлалыг хаашаа явах, хэдэн хүний бүрэлдэхүүнтэй зохион байгуулах ажлыг шийдвэрлэхийг ҮЗЗ-ийн Хяналтын хорооны гишүүдэд үүрэг болгон өгсөний дагуу Дорнод, Хэнтий, БСШУЯ, Хорих 429-р анги, МУЗН дээр очсон. • ҮЗЗ-ийн даргын тухай асуудлыг дараагийн 76 дахь хурал дээр шийдвэрлэхээр хойшлуулсан. 	ҮЗЗ-Н ГИШҮҮД	100%
Хөтөлбөр #2	ҮЗЗ-ийн дүрмийг хэлэлцэн, эцэслэн батлах		
Ашиг сонирхолын зөрчилтэй оролцогчийн изрийг дурдана уу.			
Ямар нэгэн маргаан гарсан эсэх (тийм эсвэл үгүй)>		Тийм	

А.Нямдорж: Дүрмийн Ажлын хэсгийн ахлагч А.Нямдорж ҮЗЗ-ийн дүрмийн 1,2 дугаар бүлгийг уншиж танилцуулсан бөгөөд нэмэлт өөрчлөлт оруулсан хэсгүүдийг тодотгон тайлбарлалаа. /Хавсралт 1-Дүрмийн ажлын хэсгийн ноорог / Түүнчлэн энэхүү дүрмийг нэмж засварлахдаа ҮЗЗ-ийн гишүүн асан Н.Амарсайханы дүрмийн ноорог /Хавсралт 2/ болон одоо баримталж буй дүрэм дээр тулгуурлан ажилласнаа мэдэгдсэн. Тэдгээрээс хамгийн гол асуудал нь журам болгосон байнсыг дүрэм хэвээр үлдээх санал байлаа. Ингээд эхний 2 бүлэг дээр гишүүдийн саналыг асууснаар хурал цааш үргэлжиллээ.

Хэлэлцэн асуудлууд дээр гишүүдээс гарсан санал, тодруулга

ХЭҮК	<p>Г.Золзаяа: Одоо баримталж буй дүрэм дээр ХЭҮК бие даасан байдлаар орсон байсан ч энэ шинэ дүрэм дээр байхгүй байна. Үүнийг 1-т ямар үндэслэлээр хасаж байгаа вэ? 2-т ХЭҮК орж байгаа юу эсвэл цаашид оруулахгүй байхаар зохицуулсан уу? 3-р бүлэгт дурдсанаар ҮЗЗ-д Төрийн байгууллагын төлөөллийг томилохдоо СЯ-аар томилуулахаар зохицуулсан уу? Хэрэв тийм бол энэ нь хэр зохижктой вэ?</p> <p>Одоогийн баримталж буй дүрэм дээр байгууллагын нэр зоосон байсан нь зохижктой байсан гэж үзэж байна.</p>
ТББ	<p>Б.Мөнхцэцэг: Өмнөх ҮЗЗ-ийн гишүүдийн тоог ямар үндэслэлээр нэмсэн бэ?</p> <p>Түүнчлэн 3 жилийн хугацаатай байнсыг яагаад 2 жилийн хугацаатай болгож байна вэ?</p>
ТБ	<p>Д.Ганцэцэг: Энэ дүрэм дээр ТБ болон ТБ-ын төлөөлөл харилцан тэнцвэргүй байгаа нь зохижгүй санал болжээ. Шинжлэх ухаан, боловсролын салбарын төлөөлөл 2 гэсэнд ТБ орж байгаа юу? Энэ ТБ гэдэгт зөвхөн манай ЭМЯ-ны төлөөлөл орж байна уу? эсвэл бусад бүх энд байгаа ТБ-ын төлөөлөл болох УАБЗ, ХЭҮК орох уу? Бид урд нь зөвхөн ЭМЯ-ны зүгээс 4 мэргэжилтэн Хяналтын хороо болон Гүйцэтгэх хороонд оруулахаар санал дэвшүүлж байсан. Энд мэргэжлийн байгууллагаас арга зүйгээр дэмжих үүднээс оруулах хэрэгтэй. Бид тэдгээр хүмүүсийг чадвартай цаашид мэргэжил арга зүйн дэмжлэг үзүүлээд явах боломжтой гэдэг үүднээс томилох саналыг тавьсан. Тиймээс ТБ-ын төлөөлөл 4 байна гэдэг нь боломжгүй тоо юм.</p> <p>Ажлын хэсгийг хангалттай ажилласан гэж үзэхгүй байгаа тул Дүрмийн Ажлын Хэсэгт бид ТБ-г төлөөлөн орж ажиллах саналтай байна. ДОХ, сурьеэгийн асуудал бол улс орны хэмжээнд авч үзэх шаардлагатай том асуудал юм. Тиймээс энэ төрлийн төсөл хөтөлбөрүүд Засгийн Газрын бодлоготой уялдаатай байх хэрэгтэй.</p>
ТБ	<p>Ж.Мөнхжаргал: Ерөнхий үйл ажиллагааг хангахад ҮЗЗ-д гишүүн сонгох үйл явц, бүрэлдэхүүн гишүүнчлэлтий холбогдохгүй байна. Учир нь Д.Ганцэцэг гишүүнтэй би санал нэгтэй байна. ТБ-ын төлөөлөл 4 гэж тавиад, тэдгээрийн 2 нь шинжлэх ухаан, боловсролын байгууллагын төлөөлөл гэжээ. Харин ТББ хангалттай байж байхад дээрээс нь тоог 10 орчмыг нэмсэн байна. Үүнд ТББ-5 дээрээс нь ОУБ-4, Халдвартай олон нийт-4 гээд дээрээс нь дахиад Эрсдэлт бүлгийн төлөөллийг-2 гээд нэмж оруулсан байна. Энэ хүмүүс нь олон орохгүй байгаад асуудал шийдэгдэхгүй байна уу? Ямар нотолгоон дээр үндэслэн эдгээр тоог нэмэгдүүлсэн бэ? ТБ-г хязгаарлаж тавиад ТББ-г удаа дараа ийн нэмэгдүүлсэн нь ямар шалтгаантай вэ? Даргыг 3 жилээр сонгоод ҮЗЗ-ийн гишүүдийг 2 жилээр сонгохоор болсон байгаа нь ямар учиртай юм бэ? Энэ хугацаагаа уялдууах хэрэгтэй. Дахин төлөөллийг улируулан сонгох гэсэн асуудлыг дэмжиж байна. Харин насан туршдаа сонгогдоод байгаа гишүүдийн асуудлыг хэрхэн зохицуулах вэ?</p> <p>Тер төлөөлөх байгууллагын төлөөллийн тоог нэмэгдүүлэх нь зүйтэй. ҮЗЗ-д УАБЗ-ын төлөөлөл байх нь Засгийн газрын бодлоготой үйл ажиллагааг уялдуулах, ЭМЯ-ны төлөөллийг оруулах нь чиглэл тодорхойлоход хэрэгтэйн дээр, инженер тоног төхөөрөмжийн мэргэжилтэн байлгах хэрэгтэй. Түүнчлэн энд дарга цэрэгтэйгээ хамт ирж суугаад байгаа хүмүүсийг бас бодолзох хэрэгтэйг анхаарна уу. Төсөл хөтөлбөр дээр алдаа дутагдал гарч, анхаарал хандуулахуйц хэсгүүдээс төлөөлөл оруулах хэрэгтэй. Харин ашиг сонирхлын асуудал үүсгэж буй бүлгүүдээс төлөөлөл оруулах эсэхээ бодолзох хэрэгтэй.</p>
Хувийн хэвшил	<p>Б.Мягмар: ТБ-ын төлөөллийг өмнөх дүрэм дээр бид маш тодорхой оруулж өгсөн. Харин энэ асуудал бүрхэг болсон байгаа тул тодруулж өгнө үү. 2.1.4-т Хөдөлмөр Нийгмийн түншлэгч байгууллага 2 байсан бөгөөд одоо 3 болсон байна. Монголын Үйлдвэрчний Эвлэл, Ажил Олгогч Эздийн Нэгдсэн Холбооноос өөр ямар байгууллага оруулах болсоноо хэлж өгнө үү.</p> <p>Гишүүдийн тоо нэмэгдэж байгаа нь үр дүнтэй байх боломжтой. Өмнө нь СЯ-наас төлөөлөл байсан боловч тэр бүр ҮЗЗ-ийн ажилд идэвхитэй оролцдоггүй байсан. Гэтэл одоо СЯ-аар төрийн байгууллагуудын төлөөллийг сонгох нь хэр үр дүнтэй байх вэ? Тиймээс ТБ-ын төлөөллийг тухайлан нэр заах нь зүйтэй гэсэн саналтай байна.</p>
ТБ	<p>Д.Ганчимэг: Гарчиг дээр бол журам бус дүрэм байх нь зүйтэй. Нийтлэг үндэслэл дээр гэрээний нэрийг бүтэн дурдан дагалдах баримт бичгийн талаар тодорхой тусгах хэрэгтэй. Мөн дүрмийн 1.3 болон 1.5-ын утга санаа давхардсан байгаа тул нэгтгэх хэрэгтэй. Агуулгаараа энэхүү дүрэм дээр сийлгомжгүй утга санаа болон давхардсан зүйлс маш их байгааг анхаарарай. Ажлын хэсэгт гишүүд бүгд өөрсдийн саналыг өгөх хэрэгтэй.</p>
ТБ	<p>Л.Бямбасүрэн: Ямар байгууллагыг төлөөлж буйгаас нь үл шалтгаалан сонгогдох төлөөллүүд нь өөрсдийн салбарыг төлөөлөх мэдлэг чадвартай, саналаа хэлэх боломжтой тодорхой шаардлагад нийцсэн чадвартай байх хэрэгтэй гэсэн саналтай байна. Харин энэ төлөөлөл ажлаа хийж чадахгүй байгаа тул тоог нь нэмэгдүүлье гэдэг</p>

	санал нь зохижүйгүй. ТБ-ын төлөөллийг б болгож нэмэгдүүлэх саналтай байна. Урд нь Y33 илүү чадвартай байсан гэж би дуулсан. Ганцхан Гүйцэтгэх Хороогоор асуудлыг шийдвэрлээд энэ хурал дээр бидний саналыг дэмжин гаралаа өргө гээд байдаг нь утгагүй зүйл гэдгийг хэлэх байна.
Хүний Эрхийн Байгууллага	С.Дондов: Агуулга, уг үсгийг сайжруулах хэрэгтэй гэсэн саналтай байна. Дүрмийн 2.1 дээрх ХЭҮК энд заавал байх шаардлагатай гэсэн саналтай байна. Гэрээний нөхцөл дээр зөвлөмж, зарчим, эрх үүрэг, хариуцлагын тогтолцоог энхүү дүрэмдээ сайтар тусган оруулж өгөх шаардлагатай гэж бодож байна.
X.O.N	Н.Тамир: Дүрмийн 2.1 дээр ДОХ, сүрьеэ өвчтэй олон нийтийн төлөөлөл урд нь 1,1 байсан. Бид энэхүүг тоог нэмэгдүүлэх шаардлага үүссэн шалтгаан бол хүсийн тэгш байдлыг хангах юм. Угаасаа ГС-ын ДОХ, сүрьеэгийн төсөлд 2 эрэгтэй, 2 эмэгтэй төлөөлүүд оролцвол бусад халдвартай олон нийтийн саналыг тусгах, тэдний дуу хоолойг илүү хүргэх утгаараа илүү хүчтэй байх болно гэдэг үүднээс энэ тоог нэмэгдүүлэх санал гаргасан. Түүнээс бус эдгээр төлөөлүүд чадваргүйдээ Y33-д сонгогдон дуу хоолойгоо хүргэхгүй байгаа хэрэг биш. Дүрмийн 2.2 дээр Эрсдэлт бүлгийн хүн амын төлөөл өгдэгт Трансжендер, ЭБЭ, ЭБУ, өнчин, ядуу хүүхэд, өсвөр үе гээд маш олон хүмүүсийг дурдаж болох бөгөөд энэ утгаараа тэдгээр хүмүүсийн саналыг тусгах үүднээс тоог нь нэмэгдүүлсэн.
XZN	А.Оюунбилэг: Би шийдвэр гаргахад нөлөө үзүүлэхгүй ч өөрийн зүгээс та бүхэнд мэдээлэл болох зүйлийг хэльв. Сангийн Яам Глобаль Сантай хамтран ажиллах хугацаагүй гэрээг байгуулсан. Тэрхүү гэрээнд Санхүүжилтын журам буюу Grant Regulation гээд тодорхой хэсэг байгаа бөгөөд түүн дээр Y33 гэж юу болох түүний бүрэлдэхүүний талаар тодорхой дурдсан байдаг. Энэхүү дүрмийг боловсруулахдаа тэрхүү журмыг баримталсан байгааг харж байна. Шинэ гишүүдэд хандан хэлэхэд хуучин ЭМЯ энэ ТБ-уудыг оруулах тал дээр удирдан явж байсан ба дараа нь “DOХ-той тэмцэх Үндэсний хороо” Y33-д ЗГ-ыг төлөөлөн ямар байгууллага байх, оролцохыг шийдвэрлэж байсан. Одоо бодоход ТБ-ыг нэрээр нь зоох нь буруу бөгөөд тэдний төлөөлөн маш олон байгууллага орох боломжтой тул үүнийг ЗГ сонгах нь зөв санагдаж байна. Энэхүү дүрмийг сайжруулан авч хэрэглэснээр цаашид урт хугацаандаа ашиглах боломжтой. Тодорхой байгууллагуудын нэр зоох нь бас л үндэслэлгүй бөгөөд яагаад зөвхөн тэдгээр байгууллагууд төлөөлөх ёстой вэ гэдгийг тайлбарлахад хангалттай үндэслэл гарч ирэхгүй л болов уу.
НУБ	А.Цэцэгмаа: Сангийн Яамны төлөөллийг Y33-ийн бүрэлдэхүүнд оруулахыг дэмжиж байна. Учир нь СЯ нь Глобаль санд Монгол Улсаа төлөөлж гэрээнд гарын үсэг зурж байна. Харин тэд бусад ТБ-ыг томилох тал дээр өөр байр суурьтай байна. Y33-өөс эдгээр байгууллагуудыг санал болгож байна гэсэн санал хүргүүлэх боломжтой. Түүнчлэн энэхүү хурал дээр би 2 дахь удаагаа сууж байна. Гэтэд бид Y33-ийн үндсэн үүргийг сайн ойлгож байгаа эсэх нь асуудалтай санагдаж байна. Бид өөр өөрсдийн тодорхой салбарыг төлөөлөн тухайн бүлгийн хүмүүсийн дуу хоолойг хүргэж, тэдгээрт энэ төслийн үр шим үнэхээр хүрч байна уу? гэдгийг хэлэлцэн, өрөнхий удирдлагаар хангаж, зөвлөмж өгөх үүрэг бүхий бүлэг хүмүүс энд ирдэг гэж ойлгож байна. Тэгэхээр эндээс улбаалан зорилго, зорилтоо тодорхойлон ажиллах хэрэгтэй санагдаж байна. Өмнө хэлсэнчлэн бид ЭМ-ийн салбарт дэмжлэг, зөвлөмж өгөх хэмжээний хүмүүс биш. ДОХ бол хүний эрхтэй нягт холбоотой тул ХЭҮК зайлшгүй байх шаардлагатай санагдаж байна.
Хариулт:	
A.Нямдорж: Н.Амарсайхан гишүүн өөрөө ТБ-г төлөөлөн энэхүү дүрмийг боловсруулсан байсан дээр бид ажилласан. Бид Глобаль Сангаас Y33-ийн гишүүдийг бүрдүүлэхэд өгдөг чиглэлүүдийг баримтлан энэ хэсгийг боловсруулсан. Тэрхүү шаардлагад Хувийн хэвшлийн 7 төрлийн байгууллага байх боломжтой гэж заасан байсан тул бид дүрэм дээр 3 болгон тоог нэмэгдүүлээд бусад дурдсан байгууллагуудыг оролцох бололцоог бүрдүүлэх үүднээс нэр заасангүй. Харин дарга болон Y33-ийн гишүүд 2 жилээр сонгогдох бөгөөд тухайн сонгогдсон салбар нь улируулан сонгохыг дэмжвэл бид гишүүнээр авч үлддэг. Харин дарга 3 жилээр сонгогдоно гэсэн заалт байхгүй. ТБ дангаараа 4 бөгөөд Глобаль сангаас өгсөн шаардлагад суурилан шинжлэх ухаан боловсролын салбарын төлөөлөлд академик болон тархвар зүйч байх ёстой гэсэн шаардлагын дагуу үүний тоог 2 болгосон. Харин ТБ-ын төлөөллийг урд нь шууд заасан байсан бөгөөд одоогийн энэхүү дүрэм дээр тодорхой заагаагүй нь Глобаль Сантай Сангийн Яам Монгол улсын Засгийн Газрыг төлөөлөн гэрээ байгуулдаг. Тиймээс Сангийн яам нь албан ёсоор ГС-ын өмнө хариуцлага хүлээж байгаа бөгөөд энэ үүднээсээ ТБ-ын төлөөллийг тэд сонгон ажиллуулах нь зүйтэй гэсэн санал гаргасан. Харин бид Сангийн Яаманд хүсэлтийг гаргахдаа одоо Y33-д ТБ-ыг төлөөлж буй байгууллагуудын мэдээллийг өгөөд сонгуулах хэрэгтэй гэсэн байр суурьтай байна. Халдвартай Олон Нийт болон Эрсдэлт бүлгийн төлөөллийн зүгээс Y33-д төлөөлөх гишүүдийн тоог нэмэгдүүлэх саналыг удаа дараа ирүүлж байсныг үндэслэсэн. Түүнчлэн ХЭҮК нь ТБ учраас Сангийн Яамаар дамжин шийдвэрлэж сонгогдох болно. НУБ-ийн байгууллага нь Олон талт хамтын ажиллагааны байгууллагад орж байна.	
Ц.Ганхүү: Бид энэхүү дүрмийг боловсруулахдаа Сангийн Яамны Глобаль Сантай байгуулсан гэрээний дагалдах журам дээр тулгуурлан ажилласан бөгөөд түүнд нийцүүлэхийг оролдсоны үндсэн дээр энэ дүрмийг боловсруулсан. Түүнчлэн ГС-тай Сангийн Яам нь Монгол Улсын ЗГ-ыг төлөөлөн гарын үсэг зурсан бөгөөд бид хоорондоо ярилцсан, хуульчдаас ч зөвлөгөө авахад тухайн субъект хэнтэй гэрээ байгуулсан эсэхээс шалтгаалан хариуцлагыг хүлээх учраас тэр байгууллагын төлөөллийг хүсэхдээ тухайн байгууллагад санаалаа явуулах шаардлагатай гэсний үндсэн дээр энэ санал гарсан.	
Шийдвэр:	
1. Y33-ийн гишүүн бүр 2018 оны 3 сарын 20-ны өдөр гэхэд Y33-ийн дүрмэн дээрх өөрсдийн саналыг нарийн	

	тусган Ажлын албандаа цахимаар тайлбарлан ирүүлэх шаардлагатай бөгөөд хэрэв дүрэм дээр ямар нэг саналгүй бол саналгүй гэсэн мэдэгдэл явуулах шаардлагатай гэсэн үргийг Y33-ийн нийт гишүүдэд өглөө.
2.	Дүрмийн ажлын хэсгийн гишүүн Ц.Ганхүү саналаараа ажлын хэсгийг орхиж, Төрийн байгууллагын төлөөлөл ЭМЯ-ны НЭМГ-ын дарга Д.Ганцэцэг Дүрмийн Ажлын Хэсэгт ТБ-г төлөөлөн орж, ХЗН арга зүйн дэмжлэг үзүүлж мэдээллээр ханган, Y33-ийн Ажлын Албаны ажилчид энэхүү дурмийн гишүүдийн ирүүлсэн санал болон бусад холбогдох материалын дээр Ажлын хэсэгтэй хамтран ажиллахаар шийдвэрлэн Y33-ийн 77 дахь удаагийн хурлаар шинэчилсэн дүрмийг батлах ажлыг дахин хэлэлцэхээр гишүүдийн олонхийн саналаар баталлаа.

Шийдвэрийг хэрхэн гаргасан талаар

Зөвшүүлцөл	x			
Санал хураалт	x	Санал хураалт (Тохиорх нүдийг бөгөөнө үү)	Гар өргөх	x
			Нууц санал хураалт	
		Дэмжсэн>		16
		Эсрэг>		
			Санал ёгөхөөс түдгэлзэх	

Хөтөлбөр #3		Одоогийн хэрэгжүүлж буй төслийн ололт амжилт, саад бэрхшээл
Ашиг сонирхолтын зөрчилтэй оролцогчийн нэрийг дурдана уу.		
Ямар нэгэн маргаан гарсан эсэх (тийм эсвэл үгүй)->		Үгүй
Тавьсан илтгэл, танилцуулгын хураангуй		
2015-2017 оны Глобаль сангийн дэмжлэгтэй ДОХ, сурьеэгийн төслийн хэрэгжилтийн байдлыг ХЗН-ийн мэргэжилтэн С.Ганзаяа, Б.Гансүх нар танилцууллаа /Танилцуулга-Хавсралт 3/.		
А.Оюунбилэг: 2018 оны 1 сарын 1-нээс эхэлсэн шинэ төслийн санхүүжилтиг Сангийн Яамны тогтоолоос үүдэн бага зэрэг саатаж 2018 оны 2 сарын 15-ны өдөр СХА-чдад өгч эхэлсэн бөгөөд одоогоор 1-2 СХА-аас бусад эхний улирлын санхүүжилтээ авсан байна. Түүнээс гадна ХЗН-д Үндэсний Аудитын Газраас 2017 оны 11 сарыас 2018 оны 3 сар хүртэл шалгалт орсон. Энэхүү шалгалтын тайлан хөтлөлт нь ГС-аас зарчмын хувьд өөр байсан бөгөөд бид тэдний шаардлагын дагуу баримт, материалыг бүрдүүлэн өгсөн. Гэвч үүний үр дүнд өөрсдийн ГС-ын шаардлагын дагуу суурилуулсан програмаа эвдсэн байдалтай байна. Түүнчлэн Y33-ийн ерөнхий чиг үүрэг, СХА-чидыг сонгон шалгаруулах журам болон бусад мэдээллийн талаар тайлбарлав. <i>Хавсралт 4/</i>		
Хэлэлцээн асуудлууд дээр гишүүдээс гарсан санал, тодруулга		
ТБ	Д.Ганцэцэг: Үндэсний Аудитын Газрын шалгалтын дүгнэлтээр ХЗН хязгаарлалттай буюу тодорхой хугацаанд засаж сайжруулах шаардлагатай гэсэн мэдэгдэл надад ирүүлсэн байсныг та бүхэнд хүргүүлсэн биз дээ.	
ТБ	Д.Ганчимэг: Сурьеэгийн төслийн 6 шалгуур үзүүлэлтийн 3 нь зорилтод хүрсэн байдалтай харагдаж байна. Мөн ДОХ-ын төслийн зарим үзүүлэлт яагаад зорилтоос давсан байгааг тайлбарлана уу.	
ТБ	Ж.Мөнхжаргал: 1. Эдгэр зорилтын суурь түвшин хэдэн оных вэ? 2. Эрүүл Мэндийн Хөгжлийн Төв дээрх тоо баримтыг авч ажиллан тогтвортой хөгжлийн бодлоготой хөл нийлүүлэн ажиллах нь зүйтэй. Энэ үр дүнд статистик дутмаг байна. Шалгуур үзүүлэлт урт хугацаанд үр өгөөжтэй байх хэрэгтэй. 3. Манай улс эдийн засгийн хувьд чадвар мутай. Тэгэхэд та бүхэн яагаад өртөг өндөртэй дижитал аппарат аваад байна вэ? Үүний оронд Флюр аппарат авч хэрэглэх нь зохимжтой санагдаж байна. 4. СХА-чдын сонгон шалгаруулалтыг хэрхэн хийдэг вэ?	
Хариулт:		
Ч.Бямбаа: 2015-2017 оны төслийг бичихдээ Улаанбаатар хотын хэмжээнд 2014 онд гаргасан судалгаан дээр үндэслэсэн. РВЭЭ хамрагдсан ХДХВ-ийн халдвартай насанд хүрэгсэд ба хүүхдүүдийн эзлэх хувь дээр гарч буй 181 гэдэг тоо нь эмчилгээ хийлгээгүй, нас барсан хүмүүсийг хассан тоо юм. Илэрсэн бүхий л тохиолдлуудаа эмчилгээнд хамруулаад явж байна. Улсын хэмжээний бүхий л илрүүлгийн 50%-ийг ТББ хийгээд явж байна. Энэхүү үр дүнгийн үзүүлэлтийг бид СОНА-д өгч, тэд тулган шалгаж ГС-д явуулдаг.		
А.Оюунбилэг: Эдгэр статистик үзүүлэлтууд ГС-ын бус ХӨСҮТ, ЭМХТ-ийн гарган бидэнд ирүүлсэн тоо юм. Бид тэдгээр байгууллагууд үзүүлэлтээ гаргаад бидэнд нэг тоо, өөр байгууллагуудад өөр тоо өгдөг гэж бодохгүй байна. Энэ нь Монгол улсын нэгдсэн үзүүлэлт бөгөөд үүн дээр тулгуурлан ажиллаж байна. 2018-2020 онд хэрэгжиж буй төсөл, хөтөлбөрүүдийн СХА-г сонгоходоо Монгол улсын Засгийн Газар, ГС-тай байгуулсан гэрээний заалтууд болон тус		

сангаас гаргасан гэрээний журмуудыг мөрдлөгө болгодог. Түүнчлэн Глобаль Сангаас 2018-2020 оны төслүүдийн хүрээнд ДОХ, Сүрьеэгийн чиглэлээр үйл ажиллагаа явуулж байсан СХА-чидтайгаа үргэлжлүүлэн хамтран ажиллах хэрэгтэй гэсэн и-мэйл ирүүлсэнийг та бүхэн хүлээн авч танилцаж болно. Гэсэн хэдий ч бид тухайн үед Глобаль Сангаас зарим нэгэн шинэ байгууллагууд СХА болж ажиллах сонирхолтой байна энэ асуудлыг дахин авч үзээч гэж хүссэний хариуд Глобаль сангаас одоо цаашид хичнэн жил энэхүү төслийг үргэлжлүүлэх нь тодорхойгүйн дээр, хэрэв шинэ СХА-тай болвол хүмүүсийг сургах болон бусад менежментийн зардал дахин гарч ирнэ. Түүний оронд тэр зардлаа өвчтөнгүүдийнхээ эмэнд зарцуулсан нь дээр. Тиймээс энэ бүхнээс урьдчилан сэргийлж, үр дүнтэй байлгахын тулд одоо ажиллаж байгаа чадвартай болсон СХА-чидтай хамтран ажиллах нь зүйтэй гэсэн зөвлөмжийг ирүүлсэний дагуу энэхүү шийдвэрийн хүрээнд ажилласан.

С.Ганзаяа: Флюр аппарат аналоги сисмемтэй суурин ашиглах зориулалттай. Харин дижитал рентген аппаратын хувьд компьютер санах ойтой бөгөөд зөөврөлөн ашиглах давуу тал нь манай Монгол орны тархан суурышдаг онцлогт илүү тохиромжтой.

Ч.Бямбаа: Төсөл хэрэгжүүлэх явцад ханган нийлүүлэлт дээр талуудын саналыг тусган ажилласан. Төслийг Y33 өргөн барьдаг. ЭМЯ-ны санал дээр Gene-xpert хэд хэдийг авах санал боловч цуцлагдсан гэдгийг ЭМЯ-ны төлөөллүүд мэдэж байгаа.

Шийдвэр:

Шийдвэрийг хэрхэн гаргасан талаар

Зөвшлийл				
Санал хураалт	Санал хураалт (Тохиরх нүдний бөглөнө үү)	Гар өргөх		
		Нууц санал хураалт		
	Дэмжсэн>			
	Эсрэг>			
Санал өгөхөөс түдгэлзэх				

Хөтөлбөр #4 2017-2018 оны Y33-ийн санхүүгийн тайлан, 2018-2019 ажлын төлөвлөгөө

Ашиг сонирхолтын зорчилтэй оролцогчийн нэрийг дурдана уу.

Байхгүй.

Ямар нэгэн маргаан гарсан эсэх (тийм эсвэл үгүй)>

ҮГҮЙ

Тавьсан илтгэл, танилцуулгын хураангуй

Б.Оюундарь: 2017-2018 оны Y33-ийн санхүүгийн тайлан /Хавсралт 5/, 2018-2019 ажлын төлөвлөгөө /Хавсралт 6/-г танилцууллаа. Y33-ийн ажлын төлөвлөгөө 3 жилээр батлагддаг бөгөөд 2017-2020 оны ажлын санхүүжилтын хүсэлт баталгаажсан. 2017 оны 4 сараас 2018 оны 3 сарын 31-нээр дуусгавар болох санхүүжилт зарцуулагдаж байгаа бөгөөд 2018 оны 1 дүгээр сараас өдийг хүртэлх санхүүжилт орж ирээгүйтэй холбоотойгоор зарим нэг үйл ажиллагаа хоцорсон. Түрээс, утас, интернетийн төлбөр болон үйл ажиллагаатай холбоотой зарим зардлууд гараагүй учраас өдөр тутамын үйл ажиллагааг явуулхад хүндрэлтэй байна. Гэсэн хэдий ч төлөвлөгөөт үйл ажиллагаануудыг ямар нэгэн аргаар зохион байгуулж тогтвортой байдлыг хангахын төлөө ажлын алба ажиллаж байна.

Бид өнгөрсөн 11 дүгээр сард СХА-чдын үйл ажиллагаатай танилцах айлчлалыг зохион байгуулсан бөгөөд тийн явж байх хугацаанд Y33-ийн гишүүд СХА-тай уулзах уулзалтыг зохион байгуулж тэдгээр байгууллагуудтай мэдээлэл солилцсоны үндсэн дээр хөтөлбөрийн хэрэгжилттэй танилцах ажлыг зохион байгуулвал илүү үр дүнтэй болох тухай санал гарсаны үндсэн дээр ажлын төлөвлөгөөнд тус шинэ үйл ажиллагааг нэмж оруулсан. Бусдаараа бол батлагдсан төсвийн дагуу үйл ажиллагаа нь хэвээрээ байгаа. Та бүхэнд үүнтэй холбоотой санал асуулт байвал асууна уу.

XZN	A.Оюунбилэг: XZN, YXA-аас улирал бүр СХА-тай уулзах уулзалтыг зохион байгуулдаг байхад Y33 дахин СХА-тай уулзах уулзалт зохион байгуулах хэрэгцээ байна уу? XZN-ийн зохион байгуулдаг хуралд Y33-ийн гишүүд оролцоогоо ханган санал бодлоо хуваалцаад явах нь ижил утгатай олон төрлийн хурал уулзалт зохион байгуулснаас илүү үр дүнтэй гарц байх болно.
TB	Л.Бямбасүрэн: Y33-ийн ээлжит хурлуудаар ДОХ, Сүрьеэгийн СХА-чдыг оролцуулан хийж буй ажлаа танилцуулан Y33-ийн шинэ гишүүдэд мэдээлэл өгөх байдлаар зохион байгуулах хэрэгтэй. Ингэснээр Y33 чиг үүргийнхээ дагуу СХА-чидтай уялдаа холбоогоо сайжруулан удирдах бололцоо бүрдэх тул энэхүү саналыг гаргаж байна. Түүнчлэн Ажлын албандаа эрх зүйч мэргжилтэй хүн ажиллах нь ач холбогдолтой гэдгийг өмнө сануулж байснаа дахин хэлээд энэ тал дээр анхаарал хандуулахыг хүсэж байна.
Хувийн хэвшин	Б.Мягмар: Энэхүү санал дээр нэмж хэлэхэд СХА-чид үйл ажиллагаагаа танилцуулахдаа шинэ гишүүдэд ойлгомжтой товч байдлаар тайлбарлан танилцуулах хэрэгтэй. YXA нь СХА-чидтай хамтран ажиллах гэрээ байгуулахдаа Y33-ийн оролцоог хангах хэрэгтэй гэдгийг хэлмээр байна.

Шийдвэр:																	
СХА-чдын хурлыг зохион байгуулахын оронд ҮЗЗ-ийн ээлжит хурлуудаар СХА-дыг урьж оролцуулан хийж буй ажлаа танилцуулан ҮЗЗ-ийн шинэ гишүүдэд мэдээлэл өгөх байдаар зохион байгуулах хэрэгтэй гэсэн саналыг тусгахыг хүсэн ҮЗЗ-ийн 2018-2019 оны Ажлын төлөвлөгөөг гишүүд санал нэгтгэйгээр дэмжин баталлаа.																	
Шийдвэрийг хэрхэн гаргасан талаар																	
Зөвшилцөл	x																
Санал хураалт	x	<table border="1"> <tr> <td>Санал хураалт (Тохирох нүдний бөглөнө үү)</td><td>Гар өргөх</td><td>x</td></tr> <tr> <td></td><td>Нууц санал хураалт</td><td></td></tr> <tr> <td>Дэмжсэн></td><td>15</td><td></td></tr> <tr> <td>Эсрэг></td><td></td><td></td></tr> <tr> <td colspan="2">Санал өгөхөөс түдгэлзэх</td><td></td></tr> </table>	Санал хураалт (Тохирох нүдний бөглөнө үү)	Гар өргөх	x		Нууц санал хураалт		Дэмжсэн>	15		Эсрэг>			Санал өгөхөөс түдгэлзэх		
Санал хураалт (Тохирох нүдний бөглөнө үү)	Гар өргөх	x															
	Нууц санал хураалт																
Дэмжсэн>	15																
Эсрэг>																	
Санал өгөхөөс түдгэлзэх																	
Хөтөлбөр #5	<p>Бусад</p> <ul style="list-style-type: none"> • ҮЗЗ-ийн Хяналтын Хорооны бүтэц • ҮЗЗ-ийн дарга 																
Ашиг сонирхолын зорчилтэй оролцогчийн изэрийг дурдана уу.																	
Байхгүй.																	
Ямар нэгэн маргаан гарсан эсэх (тийм эсвэл үгүй)>	ҮГҮЙ																
Тавьсан илтгэл, танилцуулгын хураангуй																	
Б.Мягмар: ҮЗЗ-ийн дарга болон Хяналтын хорооны бүтцийн талаар бид хэлэлцэх ба ҮЗЗ-ийн дарга, дэд даргаар 1 салбар чиглэлийн 2 хүн байж болохгүй гэсэн захидал ирж байсантай холбоотойгоор эдгээр асуудлыг хэлэлцэх болно. Б.Оюундарь: Бүсийн Менежер Манабаас ирүүлсэн захидалыг гишүүдэд танилцууллаа. /Хавсралт 7/ ЭМЯ-ны удирдах түвшний албан тушаалтан ҮЗЗ-ийн дарга эсвэл дэд даргаар ажиллавал төслийн хэрэгжилтийн тогтвортой байдалд эзрэгээр нөлөөлөх ба тус асуудлыг нэг дарга, хоёр дэд даргатай байж болох бусад орны туршлагыг харгалzan үзэж, шийдвэрэх хувилбарыг санал болгож байсан.																	
Хэлэлцэн асуудлууд дээр гишүүдээс гарсан санал, тодруулга																	
ТБ	<p>Д.Ганцэцэг: Бид Манабыг Монгол улсад ирэх үед уулзахад тэрээр энэхүү асуудлыг дурдаад ДЭМБ-ын суурин төлөөлөгч Dr.Cу энэ асуудлыг түүнд санал болгосныг хэлж байсан. Урд нь манай ЗГ тогтвортгүй байсан бөгөөд харин одоо харьцангуй тогтвортой болсон байгаа тул энэ асуудлыг нааштайгаар шийдвэрлэх боломжтой гэсэн саналтай байна. Бусад орны туршлагын хувьд ЭМЯ нь ҮЗЗ-г тогтвортой сайн авч явж байна. Тиймээс ЭМЯ ҮЗЗ-ийнхөө удирдлагыг гартаа аваачээ гэсэн саналыг гаргаж байсан. Бидний зүгээс харахад Дэд сайд маань энэ чиглэлийн асуудлыг маш сайн авч явж байна.</p>																
ТББ	<p>Ц.Ганхүү: Бид төсөл, хөтөлбөрийн асуудлыг шийдвэрлэн мэргэжлийн түвшинд ажиллах шаардлагатай. Би энд анх ороод YXA-ЭМЯ-г ҮЗЗ-ийн удирдлагад оруулах хэрэгцээтэй эсвэл Гүйцэтгэх хороонд оруулах хэрэгтэй гэсэн саналыг дэвшиүүлж байсан. Гэтэл энд ашиг сонирхлын зөрчил гэдэг асуудал гарч ирээд шийдэгдэггүй. Гишүүний хувьд Манабын гаргасан саналыг дэмжиж буйгаа үүгээр илэрхийлье. Бидний ажил ЭМЯ-YXA санхүүжилт өгөх тал дээр гацааг байдлыг нааштайгаар шийдвэрлэх, дахин санхүүжилт орж ирэхгүй төсөл эхлэхэд улирлаар хоцроодог байдлыг шийдвэрлэх өгөхийг хүсэж байна. Тиймээс цаашдын үйл ажиллагаа, үзүүлэлтэнд нөлөөлөл үзүүлэх эдгээр асуудлыг шийдвэрлүүлэн ажиллахыг хүсэж байна.</p>																
ДЭМБ	<p>Др.Сергей Диордица: Миний хувьд шинэ ч гэсэн Dr.Cу надад мэдэгдэж байснаас гадна миний хувийн туршлагаас авч үзэхэд ҮЗЗ-ийн даргаар ЭМЯ-ны сайд, ТНБД болон НЭМГ-ийн дарга байсан улс орнуудад ажилилж байсан. Тиймээс миний хэлэх байр суурь бол оролцоог хангасан хамгийн өндөр түвшний ЗГ-ын төлөөлөл байхыг дэмжиж байна. Түүнчлэн ирээдүйн шилжилтийг бодолцон үзэж Сангийн Яамны төлөөллийг ҮЗЗ-д оролцуулж ажиллах нь зүйтэй.</p>																
ТББ	<p>Б.Мөнхцэцэг: Бидний баримталж буй 2017 оны 1 сарын 25-нд батлагдсан дүрмийн 5.1.4-т энэ талаар Глобаль сангийн дэмжлэгтэй хэрэгжиж буй төслийн Үндсэн хүлээн авагч нь ҮЗЗ-ийн дарга байж болохгүй гэж тусгасан байгаа нь ойлгомжгүй байна. Энэ асуудлыг яаж шийдэх вэ?</p>																
ТББ	<p>А.Нямдорж: Миний харж байгаагаар 2003 оноос өдийг хүртэл анх удаа ЭМЯ-ны төлөөлөл ҮЗЗ-ийн дарга байх хэрэгтэй гэсэн санал гарч байна. Гэхдээ ер нь бид тухайн үеийнхээ нөхцөл байдлыг даган шийдвэрийг гаргах хэрэгтэй. Одоо манай төсөл хөтөлбөр ЭМЯ дээр санхүүжилт болон үйл ажиллагаан дээр гарын үсэг</p>																

	зураагүйгээс үүдэн гацхидаг тиймээс энэхүү асуудлыг шийдвэрлэх, төсөл хөтөлбөрийн үр дүнг сайжруулах үүднээс ЭМЯ-ны төлөөлөл Y33-г удирдах нь зүйтэй гэсэн саналыг дэмжиж байна.			
ТБ	Д.Ганцэцэг: Бид өнгөрсөн 1 жилийн хугацаанд энэ төсөл хөтөлбөрийн үйл ажиллагаанд идэвхитэй оролцож байна. Гэхдээ энэ төсөл хөтөлбөрүүдийг цалгардуулж байгаа асуудал ганцхан ЭМЯ дээр бус Сангийн Яам дээр гацах тохиолдлууд ч бас байдаг. Тиймээс Санхүүжилт дээр гарын үсэг зурдаг хүн ч энд орох боломжтой гэсэн саналыг дэмжиж байна.			
ТБ	<p>Ж.Мөнхжаргал:</p> <ol style="list-style-type: none"> Энэ асуудал 2 хүний захидал дээр л үндэслэгдээд байна. Тэгвэл энд Монгол орны эрх чөлөө, тусгаар тогтнол хаана байна вэ? ЭМ-ийн Дэд сайд хэн байх нь ерөөсөө хамаагүй. Албан тушаалынхаа хүрээнд тухайн салбарт Монгол улсад хэрэгжиж буй бүхий л төсөл хөтөлбөрийг хариуцдаг. Тэдгээрийн saatlyg арилгаж, аливаа үүссэн асуудлуудыг зохицуулах, санхүүжилт аль шатанд гацсан, тендер шалгаруулалтын ажлын хэсгийн үйл явц, хуулийн биелэлт зэргийг авч үзэх бүрэн боломжтой. Хуулийг зөрчиж буй эсэхийг аваад үзэх бүх боломж нээлттэй байгаа. Гэтэл өнөөдөр ийм бэрхшээл тултал гацахгүй, энэ ажлыг хариуцаж байгаа хүмүүсийг илүү хараад ч байгаа юм шиг. Бас зарим талаараа буруу ойлголттой. Ингэж яваад гацаачихсан. Цаанаа ажил нь явдаггүй, ажлаа явуулахын тулд янз бүрийн арга хэрэглэдэг л юм байна л даа. Би тэр асуудлыг чинь ойлгож байна. Тэгэхээр гарах гарц нь удирдлагaa сольё гэдэг дээр тогтох байгаа юм байна. Би үүний эсрэг байр суурь барихгүй байна. Гэхдээ дараах зүйлсийг сануулахыг хүсэж байна. Хэн нь ч дарга болсон Төрийн болон Төрийн бус байгууллагын аль нь ч байсан Монгол улсад хэрэгжиж буй хууль, тогтоомжийг хатуу баримтлан, салбар нэгж сонгон шалгаруулах тендерийг зарлан сонгон шалгаруулалтаа хий, битгий бэлэглээд бай. Y33-д өөрсдийн төлөөллийг оруулж суулгачихаад, энэ мэдээллийг илүү авч байгаагынхаа эрхээр санхүүжилтээ авах урсгалыг гаргаад ав. Ийм учраас өнгөрсөн жил УАБЗ-өөс энэ асуудал руу нилээн орсон байна. Ялангуяа төсөл хэрэгжүүлж байгаа хүмүүс энэ асуудлыг мэдэж байгаа. Тэгэхээр энийгээ бас цэвэр байлга. Цонх хаалгыг нь нээх, зөв байх, хуулиа барих тал дээр сайн ажиллаарай. 			
Хувийн хэвшин	Б.Мягмар: Миний хувьд Дэд сайд төсөл хөтөлбөрийг удаагаад байсан зүйл байхгүй. Харин ТНБД болон санхүүжилт хариуцсан дарга нь байх нь зүйтэй гэсэн А.Нямдорж даргын саналыг дэмжиж байна.			
Харинуулт:				
Шийдвэр:				
Y33-ийн Хяналтын хорооны бүтэц болон даргын тухай асуудлыг дараагийн 77 дахь хурлаар буюу дүрэм батлагдсаны дараа шийдвэрлэхээр хойшлууллаа. Энэхүү хуралд ирэхдээ ЭМЯ-ны зүгээс ЭМ-ийн Дэд Сайд, ТНБД, Санхүү хөрөнгө оруулалтын хэлтсийн дарга нарын аль нэгийг оруулах тал дээр хуралдан хурлын шийдвэрийг авч ирэхээр шийдвэрлэв.				
Шийдвэрийг хэрхэн гаргасан талаар				
Зөвшлилцөл	x			
Санал хураалт	x	Санал хураалт (Тохирох нүдийг ботглонө үү)	Гар өргөх Итууц санал хураалт	x
		Дэмжсэн>	21	
		Эсрэг>		
		Санал өгөхөөс түдгэлзэх		

ШИЙДВЭР, АВАХ АРГА ХЭМЖЭЭ			
Хөтөлбөр		ХАРИУЦАЖ БҮЙ ХҮН	ХУГАЦАА
хөтөлбөр#2	<p>1.Y33-ийн гишүүн бүр 2018 оны 3 сарын 20-ны өдөр гэхэд Y33-ийн дүрмэн дээрх өөрсдийн саналыг Ажлын албанццахимаар тайлбарлан ирүүлэх шаардлагатай бөгөөд хэрэв дүрэм дээр ямар нэг саналгүй бол саналгүй гэсэн мэдэгдэл явуулах шаардлагатай гэсэн үүргийг Y33-ийн нийт гишүүдэд өглөө.</p> <p>2.Дүрмийн ажлын хэсгийн гишүүн Ц.Ганхүү саналаараа ажлын хэсгийг орхиж, Төрийн байгууллагын төлөөлөл НЭМГ-ын дарга Д.Ганцэцэг ажлын хэсэгт орж, ХЗН арга зүйн дэмжлэг үзүүлэн, Y33-ийн Ажлын Албаны ажилчид энэхүү дүрмийн гишүүдийн ирүүлсэн санал болон бусад холбогдох материалууд дээр Ажлын хэсэгтэй хамтран ажиллахаар</p>	АЖЛЫН АЛБА, ХЗН	

	шийдвэрлэн ҮЗЗ-ийн ээлжит 77 дахь хурлаар шинэчилсэн дүрмийг батлах ажлыг дахин хэлэлцэхээр гишүүдийн олонхийн саналаар баталлаа		
хөтөлбөр#4	СХА-чдын хурлыг зохион байгуулахын оронд ҮЗЗ-ийн ээлжит хурлуудаар СХА-дыг урьж оролцуулан хийж буй ажлаа танилцуулан ҮЗЗ-ийн шинэ гишүүдэд мэдээлэл өгөх байдлаар зохион байгуулах хэрэгтэй гэсэн саналыг тусгахыг хүсэн ҮЗЗ-ийн 2018-2019 оны Ажлын төлөвлөгөөг гишүүд санал нэгтэйгээр дэмжин баталлаа.	АЖЛЫН АЛБА, СХА	
хөтөлбөр#5	ҮЗЗ-ийн Хяналтын хорооны бүтэц болон даргын тухай асуудлыг дараагийн 77 дахь хурал дээр дүрэм шийдвэрлэхээр хойшлууллаа. Энэхүү хуралд ирэхдээ ЭМЯ-ны зүгээс ЭМ-ийн дэд сайд, ТНБД, Санхүү хөрөнгө оруулалтын хэлтсийн дарга нарын аль нэгийг оруулах тал дээр хуралдан хурлын шийдвэрийг авч ирэхээр боллоо.	ҮЗЗ-Н ГИШҮҮД	

ДАРААГИЙН ХУРАЛ(ОГНОО, ХӨТӨЛБӨР)

Огноо	2018 оны 4 дүгээр сар
Хэлэлцэх асуудлууд	Хөтөлбөр

Хавсралт материал	Тохирх нүдийг бөглөнө үү	
	Тийм	Үгүй
Оролцогчдын бүртгэл	X	
Хөтөлбөр	X	
Бусад /илтгэлүүд/	X	
Хавсралт 1-10	X	

БЭЛТГЭЛ АЖИЛ(Тохирх нүдийг бөглөнө үү

	Тийм	Үгүй	
Хурлын тов, хөтөлбөрийг хурал болохоос 7 хоногийн өмнө хүргүүлсэн эсэх	x		7 хоног
Бүртгэлийн хуудас	x		Хуралд оролцсон бүх хүмүүс
Хурлын тэмдэглэлийг хурал болсоноос 7 хоногийн дотор явуулах	x		7 хоног
Хүргүүлсэн тэмдэглэлд гишүүд саналаа өгөх, нэмэх, батлах	x		Цахим хаягаар
Хурлын тэмдэглэлийг гишүүд болон оролж ирсэн төлөөлөлд хүргүүлж байх	x		ҮЗЗ-ийн цахим хуудсанд 15 хоногийн дотор байршуулах

ТОВЧИЛСОН ҮГ:

Төвчлөл	Үтга
ЭМЯ	Эрүүл Мэндийн Яам
ЗГ	Засгийн Газар
СЯ	Сангийн Яам
ТБ	Төрийн Байгууллага
ҮЗЗ	Үндэсний Зориуулах Зөвлөл
ТББ	Төрийн Бус Байгууллага
ДЭМБ	Дэлхийн Эрүүл Мэндийн Байгууллага
НҮБ	Нэгдсэн Үндэсний Байгууллага
ТНБД	Төрийн Нарийн Бичгийн Дарга

ХЗН	Хөтөлбөр Зохицуулах Нэгж
ЭМ	Эрүүл Мэнд
ХЭҮК	Хүний Эрхийн Үндэсний Комисс
ҮАБЗ	Үндэсний Аюулгүй Байдлын Зөвлөл
УХА	Үндсэн Хүлээн Авагч
СХА	Салбар Хүлээн Авагч

БАТАЛСАН:			
Нэр>	Б.Мягмар	DATE >	2018 оны 3 сарын 16
Албан тушаал>	ҮЗЗ-ийн дарга	Гарын үсэг>	


ТЭМДЭГЛЭЛ ХӨТӨЛСӨН:			
Нэр>	Л.Номин-Эрдэнэ	Огноо>	2018 оны 3 сарын 16
Албан тушаал>	ҮЗЗ-ийн ажилтан	Гарын үсэг>	



ТОВЧИЛСОН ҮГ:

Товчлол	Үтга
ЭМЯ	Эрүүл Мэндийн Яам
ЗГ	Засгийн Газар
СЯ	Сангийн Яам
ТБ	Төрийн Байгууллага
ҮЗЗ	Үндэсний Зорицуулах Зөвлөл
ТББ	Төрийн Бус Байгууллага
ДЭМБ	Дэлхийн Эрүүл Мэндийн Байгууллага
НУБ	Нэгдсэн Үндэсний Байгууллага
ТНБД	Төрийн Нарийн Бичгийн Дарга
ХЭН	Хөтөлбөр Зохицуулах Нэгж
ЭМ	Эрүүл Мэнд
ХЭҮК	Хүний Эрхийн Үндэсний Комисс
ҮАБЗ	Үндэсний Аюулгүй Байдлын Зөвлөл
ҮХА	Үндсэн Хүлээн Авагч
СХА	Салбар Хүлээн Авагч

БАТАЛСАН:

Нэр>	Б.Мягмар	DATE >	2018 оны 3 сарын 16
Албан тушаал>	ҮЗЗ-ийн дарга	Гарын үсэг>	

ТЭМДЭГЛЭЛ ХӨТӨЛСӨН:

Нэр>	Л.Номин-Эрдэнэ	Огноо>	2018 оны 3 сарын 16
Албан тушаал>	ҮЗЗ-ийн ажилтан	Гарын үсэг>	

